



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 8 сарын 17 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаартай “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралт, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2023/25-11-ШТА-ГА) тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Д.Сумъяабазар), Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга (Х.Эрдэнэбилэг) нарт зөвлөсүгэй.

3.Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2024 оны 2 дугаар улиралд гаргаж танилцуулахыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтэс (Э.Мөнхмандах)-т үүрэг болгосугай.

4.Тайланг Үндэсний аудитын газар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газарт тус тус хүргүүлсүгэй.



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Зээл, тусламжийн хөрөнгөөр хөдөө аж ахуйн салбарт хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүд нь олон нийтийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, байгаль орчинд ээлтэй, иргэдийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэхүйц арга хэмжээнүүд болжээ.



АУДИТЫН СЭДЭВ: ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ

Улаанбаатар хот
2023 он

(НТАГ-2023/25-11-ШТА-ГА)

Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үг	2
	Хүснэгтийн жагсаалт	3
Нийслэл дэх Төрийн аудитын газар	Графикийн жагсаалт	3
	Дүрслэлийн жагсаалт	3
Гүйцэтгэл-Нийцлийн аудитын хэлтэс		
Хэлтсийн дарга	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	4
Э.Мөнхмандах	Ерөнхий мэдээлэл	5-6
Аудитын менежер:	Бүлэг 1. А. Засгийн газрын шугамаар авсан зээлийг үр дүнтэй ашиглаж байна уу?	7-10
Л.Саранбаатар	А.1. Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь хөдөө, аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой уялдаж байна уу?	7-7
Ахлах аудитор:	А.2. Хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлийн хөрөнгийн ашиглалт, хэрэгжилт үр дүнтэй байна уу?	8-10
Г.Чулуунцэцэг		
Аудитор: 3.Болд	Бүлэг 2. Б. Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийн ашиглалт үр өгөөжтэй байна уу?	11-16
3.Баярбилэгт	Б.1.Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь салбарын бодлоготой уялдаж байна уу?	11-14
	Б.2 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийг тогтоосон хугацаанд үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?	14-16
Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө "Г" корпус, Утас: 327787	Бүлэг 3. В.Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо үр нөлөөтэй байна уу?	17-19
Тайланг НТАГ-ын http://audit.mn/ веб сайтаас үзнэ үү.	В.1. Зээл, тусламжийн хөрөнгийг олгох, хэрэгжүүлэх, ашиглахад тавих хяналт үр дүнтэй байна уу?	17-18
	В.2. Зээл, тусламжийн ашиглалтад дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцож байна уу?	18-19
	Аудитын дүгнэлт	20
	Аудитын зөвлөмж	21

Товчилсон үг	
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ААН	Аж ахуй нэгж
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БНСУ	Бүгд найрамдах солонгос улс
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУ	Монгол Улс
НД	Налайх дүүрэг
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НХХААГ	Нийслэлийн хүнс хөдөө аж ахуйн газар
НӨАУГ	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТББ	Төрийн бус байгууллага
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлчилгээний газар
ОУБ	Олон улсын байгууллага
СХД	Сонгинохайрхан дүүрэг
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХУД	Хан-Уул дүүрэг
ХҮХҮ	Хүнсний үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ
ХАА	Хөдөө аж ахуй
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЧД	Чингэлтэй дүүрэг

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	ЗГ-ын шугамаар нийслэлтэй хамтран ажиллах гэрээтэй зээлийн төслүүд	5
Хүснэгт 2	Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжаар хэрэгжиж буй төслийн жагсаалт	6
Хүснэгт 3	Гадаадын тусламжаар хэрэгжсэн ТАХ	12
Хүснэгт 4	2016-2020 онд малчдад олгосон урамшуулал	14
Хүснэгт 5	Хүнсний ногооны үрийн дэмжлэг	15
Хүснэгт 6	Нийслэлийн бүсэд үр тариан дэмжлэг үзүүлсэн иргэдийн ургац хураалтын мэдээ	19

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Дүрслэл 1	“МБҮ трейд” ХХК мал, мах боловсруулах үйлдвэрийн явц	8
Дүрслэл 2	“Дэвшил трейд” ХХК шилэн хүлэмж	8
Дүрслэл 3	Зээлээр чацарганын суулгац авсан иргэдийн тариалалт	9
Дүрслэл 4	“Баянгол цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ зээлээр авсан хүлэмж	9
Дүрслэл 5	Жишиг гудамж төсөл	12
Дүрслэл 6	Жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэр	12
Дүрслэл 7	Кореан Эйрийн төгөл	13
Дүрслэл 8	Агро парк тарвасын хүлэмж	13
Дүрслэл 9	ЗГ-ын зээл, хандивлагч орны хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-үүд	17
Дүрслэл 10	Нийслэлийн бүсэд НХХААГ-аар дамжуулан хүнсний ногооны хөнгөлөлттэй үр олгосон ажлын биелэлт	18

Графикийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
График 1	ТАХ-ны тоо	6

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйл, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоол, НТАГ-ын 2023 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн хийв.
Аудитын зорилт	“Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр гүйцэтгэсэн. Үүнд: ✚ Засгийн газрын шугамаар авсан зээлийг үр дүнтэй ашиглаж байгаа эсэх; ✚ Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийн ашиглалт үр өгөөжтэй байгаа эсэх; ✚ Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо үр нөлөөтэй эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг НЗДТГ, НХХААГ, “Бэлчээрийн менежмент” ОНӨААТҮГ, дүүргүүдийн хүнс хөдөө аж ахуйн хэлтэс, тасаг холбогдох бусад газруудыг хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС 100, 300, 3000-3100, Төрийн аудитын стандарт MNS 6817:2020, “МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, нөхцөл байдлын шинжилгээ хийх, газар дээр нь тулган баталгаажуулах зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтсийн дарга Э.Мөнхмандах хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Саранбаатар хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Чулуунцэцэг, аудитор З.Болд, З.Баярбилэгт нар гүйцэтгэв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Нийслэлд Хөгжлийн банк, Хаан банк, Тариалан эрхлэлтийг дэмжих сан зэргээр дамжуулан санхүүжигдсэн Монгол улсын ЗГ-ын эх үүсвэртэй зээлийн 4 ТАХ, Швейцарын хөгжлийн агентлаг, Канадын АДРА ОУБ, БНСУ-ын КОЙКА ОУБ, Кореан эйр компанийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 7 ТАХ хэрэгжсэн байна.

Зээлийн хөрөнгөөр:

Нийслэлийн хэмжээнд 2016-2022 оны байдлаар ЗГ-ын зээлийн шугамаар ХАА-г дэмжих сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Хөгжлийн банк, Хаан банк зэргээр дамжин авсан 123,051.6 сая төгрөгийн дүн бүхий 4 ТАХ байна. Үүнээс 1 ТАХ-ны зээл эргэн төлөгдөж дууссан, 2 ТАХ-ны зээл нь 2024 онд дуусах, 1 ТАХ-ний зээлийн санхүүжилт зогссон шүүхийн маргаантай байна.

Хүснэгт № 1. ЗГ-ын шугамаар нийслэлтэй хамтран ажиллах гэрээтэй зээлийн төслүүд								
(сая.төг)								
№	Хэрэгжүүлж буй төслийн нэр	Байгууллагын нэр	Он		Зээлийн зориулалт	Зээлийн		
			эхлэх	дуусах		Эх үүсвэр	Олгосон газар	Хэмжээ
1	Улаанбаатар хотын баруун, зүүн талд мал, мах боловсруулах үйлдвэр байгуулах төсөл	МБУ трейд	2017	2024	Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх төсөл нь “Нийслэлийн хүн амыг эрүүл, стандартын шаардлага хангасан нөхцөлд бэлтгэсэн хөдөө аж ахуйн гаралтай, чанартай, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах”	Засгийн газар	Хөгжлийн банк	120,000.0
2	Шилэн хүлэмжийн орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх төсөл	Дэвшил трейд ХХК	2022	2024	Газар тариалан, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих	Засгийн газар	Хаан банк	3,000.0
3	Жимс жимсгэнэ үндэсний хөтөлбөр	4 аж ахуйн нэгж, 11 иргэнд	2017	2024	ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.40.Жимс жимсгэнийн нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, чацарганын үйлдвэрлэлийн нэгдсэн сүлжээ байгуулан, хүн амыг амин дэм бүхий жимс жимсгэнээр хангах	Засгийн газар	Тариалан эрхлэлтийг дэмжих сан	23.5
4	ЕБС, СӨБ сурагчдын экологийн боловсролыг нэмэгдүүлэх хүлэмж	Баянгол цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ	2018	2019	Сурагчдын экологийн боловсролыг нэмэгдүүлэх, танин мэдэхүйн сургалт хийх, иргэдэд мод үржүүлэг, хүлэмжийн аж ахуйн чиглэлээр онол практик хосолсон сургалт зохион байгуулах	Засгийн газар	Тариалан эрхлэлтийг дэмжих сан	28.1

Буцалтгүй тусламжийн хөрөнгөөр:


Нийслэлийн хэмжээнд 2016-2022 оны байдлаар Швейцарын хөгжлийн агентлаг, Канадын АДРА ОУБ, БНСУ-ын КОЙКА ОУБ, Кореан эйр нислэгийн компани зэрэг хандивлагч орон, олон улсын байгууллагуудтай хамтран хандив тусламжаар 5 ТАХ бүрэн хэрэгжиж 2 ТАХ гэрээний дагуу он дамжин хэрэгжиж байна.

Хүснэгт №2. Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжаар хэрэгжиж буй төслийн жагсаалт

№	Санхүүжүүлэгч байгууллага	Төслийн нэр	Төслийн нийт санхүүжилт (сая.валют)	Эхэлсэн огноо	Дуусах огноо
1	Швейцарын хөгжлийн агентлаг	Налайх, Хан-Уул дүүрэгт Монгол ногоо төсөл (жишиг гудамж)	-	2017	2019
2	БНСУ-н Инчон хот	БНСУ-ын ТҮМ ТХ76 загварын трактор, дагалдах тоног төхөөрөмж хамт буцалтгүй тусламжаар нийлүүлэгдсэн.	122.3 сая төгрөг	2020	2020
3	КОИСА ОУБ	"Ногоон ази сүлжээ" ТББ-тай хамтран жимс, жимсгэнийн үйлдвэр	1,127.7 сая вон	2019	2021
4	БНСУ-н Кореан Эйр	Багануур дахь Кореан Эйрийн төгөл	-	2004	2024
5	КОИСА ОУБ	"Хүртээмжтэй мал аж ахуйн" төслийн хүрээнд сургалт, үйлдвэрлэлийн 1500 мкв-т төвийн барилгын бүтээн байгуулалт	5.4 сая доллар	2021	2036
6	АДРА Канад ОУБ	"Тогтвортой газар тариалан" төсөл	-	2012	2017
7	БНСУ-ын Гёнгсан аймгийн Хаман сум	Агро парк Тарвасын хүлэмж	41.5 сая төгрөг	2010	2020

Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-г хөдөө аж ахуйн салбараар нь авч үзвэл хүнсний ногоо жимс, жимсгэнэ, газар тариалан, ойн мод зэрэгт хэрэгжжээ. Үүнийг графикаар харуулбал:

График 1. Төслийн тоо



Дээрх төсөл, хөтөлбөрүүдэд НХХААГ, БНД, ХУД-үүдийн ЗДТГ-ууд дэмжиж хамтран ажиллах үүрэгтэйгээр санамж бичиг үйлдэн ажиллажээ.

Хандивлагч орны шугамаар хэрэгжүүлсэн ТАХ-үүдэд тухайн ОУБ нь сонгон шалгаруулалтыг явуулж бүх үе шатны хяналтыг гэрээнд заасан хугацаагаар бие даан хэрэгжүүлсээр иржээ. Харин ЗГ-ын шугамаар авсан зээлийн сонгон шалгаруулалт, хэрэгжилтэд ХХААХҮЯ хяналтыг хэрэгжүүлж НХХААГ нь хагас, бүтэн жилээр явцын мэдээг авч тайлан бэлтгэж өгөх үүрэгтэй оролцдог байна.

Мөн нийслэлд үйл ажиллагаа явуулдаг ч нийслэлээс дэмжлэггүй ОУ-ын байгууллага болон яамнаас зээл, тусламж авсан иргэдийн мэдээлэл нийслэлд бүртгэгддэггүй байна.

БҮЛЭГ А. ЗАСГИЙН ГАЗРЫН ШУГАМААР АВСАН ЗЭЭЛИЙГ ҮР ДҮНТЭЙ АШИГЛАЖ БАЙНА УУ?

А.1. Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь хөдөө, аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой уялдаж байна уу?

Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ТАХ нь ХАА-н салбарын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялджээ.

А.1.1. Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой нийцсэн төсөл, арга хэмжээг хуулийн дагуу сонгон шалгаруулж байна уу?

Нийслэлд ХАА-н зээлээр хэрэгжүүлж буй 4 төслийн 2 нь урт хугацааны, 2 нь богино хугацааны баримт бичигтэй уялдаж байна. Үүнд:

- Алсын хараа 2020-2050 урт хугацааны баримт бичгийн *“Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх”* заалтад Дэвшил трейд ХХК-ийн хэрэгжүүлж буй *“Шилэн хүлэмжийн орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх төсөл”*;
- *“Хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө орон нутгаас нийлүүлдэг органик хүнсний сүлжээ бий болгох”* заалтад “МБҮ трейд” ХХК-ийн хэрэгжүүлж буй Нийслэлийн Баянзүрх дүүргийн 11, Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороодын нутаг дэвсгэрийн 21.3 га газарт “Улаанбаатар хотын баруун, зүүн талд мал, мах боловсруулах үйлдвэр байгуулах” төсөл;
- ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн *“Жимс жимсгэнийн нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, чацарганын үйлдвэрлэлийн нэгдсэн сүлжээ байгуулан, хүн амыг амин дэм бүхий жимс жимсгэнээр ханган, экспортын орлогыг нэмэгдүүлэх ”* заалт, 2017 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 223 дугаар тогтоолоор баталсан “Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн хүрээнд чацарганын суулгацыг хөнгөлөлттэй нөхцөлөөр гэрээлэн олгосон төсөл;
- ЗГ-ын 2021-2025 оны үндсэн чиглэлийн *“жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд зориулан санхүүжилтийн шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлж, төрөөс бизнес инкубаторын үйлчилгээгээр бойжуулж, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн ур чадварыг хөгжүүлэн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх”* хүрээнд “Баянгол цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ нь 2018 онд Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас зуны 4х8 хэмжээтэй 23 ширхэг, 6х20 хэмжээтэй 2 ширхэг нийт 25 хүлэмж.

Дээрх ТАХ-үүд нь хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой нийцсэн байна.

ТАХ-ний сонгон шалгаруулалтыг нийслэл, дүүрэгт зохион байгуулдаггүй, ХХААХҮЯ-аас зохион байгуулж холбогдох сангууд, арилжааны банкнуудаар дамжуулан олгодог байна.

Дүгнэлт: ТАХ-ний сонгон шалгаруулалтыг нийслэл, дүүрэгт зохион байгуулдаггүй. Хэрэгжиж буй ТАХ-үүд нь хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой нийцэж байна.

А.1.2. Төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээнд зээл олгож байна уу?

Дээрх 4 ТАХ-ний зээлийн төлөвлөлт болон олголтод нийслэл, дүүрэг оролцоогүй байна.

А.2. Хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлийн хөрөнгийн ашиглалт, хэрэгжилт үр дүнтэй байна уу?

Хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлийг зориулалтын дагуу ашиглаж, хэрэгжиж дууссан ТАХ-үүд нь салбарын хөгжлийн бодлогын зорилтыг хангаж үр дүнтэй хэрэгжиж байна.

А.2.1. Зээлийн хөрөнгийг ашиглагч гэрээнд заасан үүргээ тогтоосон хугацаанд бүрэн биелүүлж байна уу?

Зээлийн 123,051.6 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжиж буй 4 ТАХ-ний гүйцэтгэгч нар нь гэрээнд заасан үүргээ хугацаанд нь биелүүлсэн эсэхтэй газар дээр нь очиж танилцахад: Үүнд:

1. “МБУ трейд” ХХК нь төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд Баянзүрх дүүргийн 11, Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны нутаг дэвсгэрийн 21.3 га газарт "Улаанбаатар хотын баруун, зүүн талд мал, мах боловсруулах үйлдвэр байгуулах" төслийг 2017-2024 онуудад хэрэгжүүлэхэд шаардлагатай 120,000.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн санхүүжилтийг Хөгжлийн банкнаас авсан байна. Дэд бүтэц, барилга байгууламжийн угсралтын ажил зүүн бүсэд 40%, баруун бүсэд 60% хийгдсэн ч өнөөдрийн байдлаар Хөгжлийн банкны зээлийн санхүүжилт шүүхийн маргаантай шалтгаанаар зогссон байна.

Дүрслэл № 1 “МБУ трейд” ХХК мал, мах боловсруулах үйлдвэрийн явц



Уг төсөл нь мал эмнэлгийн ариун цэврийн шаардлагад нийцсэн баталгаат бүтээгдэхүүнээр хангах зорилтыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэн нийслэлийн хүн амыг эрүүл, стандартын шаардлага хангасан нөхцөлд бэлтгэсэн хөдөө аж ахуйн гаралтай, чанартай, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах бүтээн байгуулалтын ажил байна.

2. Дэвшил трейд ХХК. “Шилэн хүлэмжийн орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх төсөл” 2022.05.20-2024.05.20-нд дуусах 3,000.0 сая төгрөгийн зээлийг ЗГ-ын 2021 оны 42, 2022 оны 117, 2022 оны 144 дүгээр тогтоолын “газар тариалан, төмс, хүнсний ногооны үйлдвэр эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих, хангамжийг тогтворжуулах” зорилгын хүрээнд олгосон байна. Уг зээл нь гэрээний үүргийн дагуу 2023 оны 6 сарын байдлаар 18.8 хувийн төлөлтийг хийсэн, зээлийн хөрөнгийн ашиглалт, хэрэгжилт хэвийн үргэлжилж байна.

Дүрслэл № 2 “Дэвшил трейд” ХХК шилэн хүлэмж



Тус компани нь газар тариалан, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжихээр ХХААХҮЯ болон арилжааны банкт байгуулсан 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн №220413/07-144/584 тоот гэрээний дагуу Хаан банкаар дамжуулан зээлийг авчээ.

Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд ХАА-н зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээ, ХАА зээлийн хүүгийн дэмжлэгийн гэрээнд хамрагдсан байна. Энэ төсөл нь Байгальд ээлтэй, усыг дахин ашиглах системтэй, ухаалаг, жилийн 4 улирал хүнсний ногоо тариалах боломжтой хүнсний аюулгүй байдлыг хангаж, үр дүнтэй хэрэгжиж байна.

3. ЗГ-ын 2017 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 223 дугаар тогтоолоор баталсан “Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 4 аж ахуйн нэгж, 11 иргэнд 12,175 ширхэг чацарганы суулгацыг хөнгөлөлттэй нөхцөлөөр нийт 28.1 сая төгрөг олгосон байна. Гэрээний заасан үүргээр эхний 3 жил зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөж сүүлийн 3 жилийн хугацаанд үндсэн төлбөрийг тэнцүү хуваан төлсөөр 2024 онд бүрэн дуусахаар байна.

Дүрслэл № 3 Зээлээр чацарганы суулгац авсан иргэдийн тариалалт



Жимс, жимсгэнийн тариалалтын талбайн хөрсний үржил шим сайжирч, тариалалт нэмэгдэж, байгалийн жимс, жимсгэнийг тарималжуулсан талбайн хэмжээ нэмэгдэж, үйлдвэрлэлийн нөөц, хэрэгцээг хангуулж экологийн цэвэр жимс, жимсгэнийг хүнсэндээ тогтвортой хэрэглэж хүн амын эрүүл мэндэд сайнаар нөлөөлжээ.

4. “Баянгол цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ нь 2017 онд Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас зуны 4х8 хэмжээтэй 23 ширхэг, 6х20 хэмжээтэй 2 ширхэг нийт 25 хүлэмжийг БГД-ийн дэмжлэгтэйгээр 28.1 сая төгрөгийн зээлийг “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-аас авч гэрээний заасан үүргийн дагуу 2017 онд 31.3, 2018 онд 34.5, 2019 онд 34.2 хувийг тус тус төлжээ.

Дүрслэл № 4 “Баянгол цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ зээлээр авсан хүлэмж



Тус хүлэмжийг ЕБС, СӨБ-ын сурагчдын экологийн боловсролыг нэмэгдүүлэх, танин мэдэхүйн сургалт хийх, иргэдэд мод үржүүлэг, хүлэмжийн аж ахуйн чиглэлээр онол практик хосолсон сургалт зохион байгуулж сургалтын бааз болгон ашигладаг байна.

Дүгнэлт: Гурван ТАХ-ний зээлийн хөрөнгийг ашиглагч тал нь гэрээнд заасан хугацаанд биелүүлэн ажиллажээ. Харин нэг ТАХ-ний зээл зогссон байна.

А.2.2. Зээлийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, арга хэмжээний ашиглалт үр дүнтэй байна уу?

Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй 4 ТАХ-ний зээл төлөгдөж дууссан 1, хугацаандаа төлөгдөж байгаа 2, хөгжлийн банкны санхүүжилт зогссон 1 ТАХ байна.

Зээлийн хөрөнгөөр санхүүжигдсэн ТАХ-ний хэрэгжилттэй танилцахад дараах байдлаар ашиглагдаж байна. Үүнд:

- “Баянгол цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ нь иргэдэд мод үржүүлэг, хүлэмжийн аж ахуйн чиглэлээр онол практик хосолсон сургалт зохион байгуулснаар үр сонгох, хөрс боловсруулах, үрсэлгээ суулгац бэлдэх, ил талбайн болон хүлэмжид тариалах анхан шатны мэдлэг олгох зорилгоор зуны 4х8 хэмжээтэй 23 ширхэг, 6х20 хэмжээтэй 2 ширхэг нийт 25 хүлэмжийг зээлээр худалдан авсан. Тус хүлэмжийг авснаар ЕБС, СӨБ-ын сурагчдын экологийн боловсролыг нэмэгдүүлэх, танин мэдэхүйн сургалт хийх, иргэдэд мод үржүүлэг, хүлэмжийн аж ахуйн чиглэлээр онол практик хосолсон сургалт зохион байгуулж сургалтын бааз болгон ашиглах мөн 2018-2021 онд хороо тус бүрээс 4-5 гишүүнтэй иргэдийн бүлэг байгуулж 1 хүлэмжид зуны хугацаанд хүнсний нарийн ногоо тарихыг практик дээр зааж, ил талбайн болон хүлэмжид тариалдаг хүнсний ногоог ангилах, тарилт хийх, зуны хугацаанд арчлах, ургац хураах, экологийн цэвэр хүнсний ногоог ургуулах арга аргачлалыг зуны саруудад бүрэн суралцаж анхан шатны мэдлэг өгсөн. Тус хүлэмжүүдийг иргэд, сурагчдын экологийн боловсролыг нэмэгдүүлэх, онол практик хосолсон сургалтуудыг зохион байгуулах чиглэлээр ашиглаж байна.
- Дэвшил трейд ХХК. “Шилэн хүлэмжийн орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх төсөл нь “Хүнсний аюулгүй байдал, иргэдийг экологийн цэвэр ногоогоор хангах, эрүүл мэндийг хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд газар тариалан, төмс, хүнсний ногооны үйлдвэр эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих, хангамжийг тогтворжуулах зорилгоор уг төслийг хэрэгжүүлж байна. “Шилэн хүлэмжийн орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх төсөл” нь байгальд ээлтэй, усыг дахин ашиглах системтэй, ухаалаг, жилийн 4 улирал хүнсний ногоо тариалах боломжтой хүнсний аюулгүй байдлыг хангасан шинэ дэвшилтэт төсөл болсон байна. 2023.06 сарын байдлаар тоног төхөөрөмжийг суурилуулах ажил дуусаж эхний тариалалт хийгдсэн байна.
- ЗГ-ын 2017 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 223 дугаар тогтоолоор “Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн хүрээнд чацарганын суулгацыг хөнгөлөлттэй нөхцөлөөр 4 аж ахуйн нэгж, 11 иргэнд нийт 12,175 ширхэг чацарганын суулгацыг олгосон нь таримал жимс, жимсгэнийн нэр төрлийг олшруулах, хэрэглэх соёлыг дээшлүүлэх, хүн амын аюулгүй, экологийн цэвэр жимс, жимсгэнийг хүнсэндээ тогтмол хэрэглэх, хүний эрүүл мэндэд сайнаар нөлөөлөх, өрхийн аж ахуйг дэмжих зэргээр үр дүнгээ өгчээ.

Дүгнэлт: Зээлийн хөрөнгөөр санхүүжсэн ТАХ-ний ашиглалт иргэн, ААН-д өрхийн үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, үр дүнгээ өгсөн байна.

БҮЛЭГ Б. ХАНДИВЛАГЧ ОРОН, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС АВСАН ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ ҮР ӨГӨӨЖТЭЙ БАЙНА УУ?

Б.1.Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь салбарын бодлоготой уялдаж байна уу?

Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ТАХ нь Монгол Улсын урт болон дунд хугацааны баримт бичигт заасан ХАА-н салбарыг хөгжүүлэх бодлогын баримт бичигтэй уялдаж байна.

Б.1.1.Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь урт, дунд, богино хугацааны бодлогыг дэмжиж байна уу?

Монгол Улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд Хөдөө аж ахуй чиглэлээр дараах зорилт арга хэмжээг тусгасан байна. Үүнд:

- Алсын хараа-2050 урт хугацааны баримт бичигт 3 үе шаттайгаар 1 зорилт 15 арга хэмжээний хүрээнд, Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх зорилтын хүрээнд “Швейцарын хөгжлийн агентлагаас хэрэгжүүлсэн Монгол ногоо төсөл”;
- Шинэ сэргэлтийн бодлого урт хугацааны баримт бичигт Хот, хөдөөгийн сэргэлт чиглэлд 1 арга хэмжээний уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад дорвитой арга хувь нэмэр оруулах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үр дүнтэй өрнүүлж, иргэн, ААН-ийг дэмжих хүрээнд БНСУ-н Кореан Эйр компанийн дэмжлэгээр “Багануур дүүрэг дахь Кореан Эйрийн төгөл”;
- Монгол Улсын ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөө аж ахуйн чиглэлээр 3 чиглэлд 34 арга хэмжээний Хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангах зорилгоор KOICA ОУБ-ын “Хүртээмжтэй мал аж ахуйн” төсөл;
- МУ-ын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 1 зорилт 15 арга хэмжээний Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрт бүтээгдэхүүнээ нийлүүлсэн малчид, тариаланчдад төрөөс урамшуулал олгох хүрээнд KOICA ОУБ-с хэрэгжүүлсэн “Ногоон ази сүлжээ” ТББ-тай хамтран жимс, жимсгэнийн үйлдвэр төсөл;
- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тогтвортой хөдөө аж ахуйн чиглэлээр 1 зорилт 15 арга хэмжээний бэлчээрийг усжуулах, худагжуулах, ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хангах зорилгын хүрээнд АДРА ОУБ-ын “Тогтвортой газар тариалан” зэрэг төслүүд нь урт хугацааны бодлогын баримт бичигтэй уялдан байна.

Мөн дээрх ТАХ нь НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Хүнс, хөдөө аж ахуйн салбарын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 7 арга хэмжээ;

2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний

хэрэгцээг дотоодоос хангах чиглэлээр 3 зорилт 11 арга хэмжээг тусган баталсантай уялдаж байна.

Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд 2016-2022 онуудад гадаадын зээл тусламж болон хандиваар 7 ТАХ хэрэгжсэнээс 2 ТАХ хугацаа дуусаагүй байна.

Хүснэгт №3 Гадаадын тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ

Д/д	Хэрэгжиж эхэлсэн он	Хэрэгжиж дуусах он	Хэрэгжсэн ТАХ	Хэрэгжиж дууссан эсэх
1	2021	2036	"Хүртээмжтэй мал аж ахуйн" төслийн хүрээнд сургалт, үйлдвэрлэлийн 1500 мкв-т төвийн барилгын бүтээн байгуулалт р	Үгүй
2	2004	2025	Багануур дахь Корейн Эйрийн төгөл	Үгүй

Дүгнэлт: Хэрэгжсэн төсөл хөтөлбөр нь МУ-н урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээнд уялджээ.

Б.1.2.Тусламж нь олон нийт, нийгмийн хэрэгцээ, шаардлагыг хангаж байна уу?

Гадаадын тусламжаар хэрэгжиж буй ТАХ-нд иргэдийг хамруулахдаа иргэдийн амьжиргааны түвшин, хэрэгцээ шаардлагыг тодорхойлон гадаадын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх байгууллагын судалгаа саналыг үндэслэдэг байна. Үүнд:

1. Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт 3 гудамж 45 өрх, иргэд хашаандаа өрхийн хэрэглээний хүнсний ногоо тарьж ургуулах, худалдан борлуулах, амьжиргааны түвшнийг дээшлүүлэх зэрэг үр дүнтэй төсөл, хөтөлбөр хэрэгжүүлжээ.

Дүрслэл №5 Жишиг гудамж төсөл



2. БНСУ-ын Олон Улсын Байгууллага (KOICA)-ын буцалтгүй тусламжаар "Ногоон ази сүлжээ" ТББ-тай хамтран НХХААГ-ийн эзэмшилд байдаг 0.5 га газарт жилд 600 тонн чацарганын жимс боловсруулах хүчин чадал бүхий "Жимс, жимсгэнийн тариалан эрхлэгчдийн сургалт, үйлдвэрлэлийн төв"-ийг иргэдийн амьдрах чадварыг дээшлүүлэх төслийн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд 2019 оны 01 сарын 10-ны өдөр барьж байгуулжээ.

Дүрслэл №6 Жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэр



Тус үйлдвэр ашиглалтад орсноор нийслэлийн ногоон хөгжлийн бодлогыг дэмжих, байгаль орчны доройтолд орсон газар нутагт жимс жимсгэнэ боловсруулах,

хүнсний ногоо тарьж ургуулах, иргэдэд сургалт явуулах, бие даах чадвар олгох, амьжиргааг дээшлүүлэх зэргээр өрхийн үйлдвэрлэлийг дэмжих бодит хөрөнгө оруулалт болсон байна.

3. 2004 оноос эхлэн Багануур дүүргийн төр захиргааны байгууллага, Кореан Эйр нислэгийн компанийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газар хоорондын байгуулсан санамж бичгийн хүрээнд 44га талбайд төгөл байгуулах ТАХ хэрэгжиж байна.

Дүрслэл №7 Кореан Эйрийн төгөл



Тус төгөл байгуулагдсанаар цөлжилт, шар шороон шуурганы эсрэг ойжуулах ажлыг эрчимжүүлэх, иргэдийг ажлын байраар хангах, нутгийн иргэдэд байгаль орчны мэдлэг олгох, Багануурын уурхайн тоосноос хамгаалах ногоон бүсийг бий болгох зэргээр олон нийтийн хэрэгцээ шаардлагыг хангасан үр дүнтэй арга хэмжээ болжээ.

4. БНСУ-ын Гёнгсан аймгийн Хаман сумын хоорондын найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд Хан-Уул дүүргийн 13 дугаар хороонд байрлах “Хан-Уул Агро” парк-д тарвасын хүлэмж байгуулах ТАХ хэрэгжсэн.

Дүрслэл №8 Агро парк тарвасын хүлэмж



Хан-Уул дүүргийн 13 дугаар хороонд байрлах “Хан-Уул Агро” паркад 50 метр урттай, найман ширхэг “Тарвасын хүлэмж”-ийг 2019 оны 07-р сард солонгос технологиор мэргэжлийн баг барьж байгуулсан нь иргэдэд солонгос технологиор тарвас тариалах сургалтад оролцох, тариалсан тарвасыг худалдан борлуулах иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зэрэг ач холбогдолтой байна.

Дүгнэлт: ХАА-н чиглэлд олон улсын байгууллагын тусламжаар хэрэгжиж буй ТАХ нь орон нутаг болон олон нийтийн хэрэгцээ шаардлагыг хангаж, үр дүнгээ өгч байна.

Б.1.3. Тусламжийн хөрөнгийг сонгох, үнэлэх, эрэмбэлэх ажил хийгдэж, шаардлагатай төсөл, арга хэмжээг хамруулсан уу ?

Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-нд тавигдах ерөнхий шаардлагыг ЗГ-ын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 4.1 дэх заалтад тусгажээ.

Журмаар Нийслэлийн ЗДТГ нь тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний төлөвлөлтийн шатанд ТАХ-г хууль, тогтоомж бодлогын баримт бичигт нийцүүлж саналыг холбогдох байгууллагад уламжлах чиг үүрэгтэй байна. Гэвч нийслэл, дүүрэгт тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-г сонгох, үнэлэх, эрэмбэлэх журмаар зохицуулаагүй байна.

Б.2 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийг тогтоосон хугацаанд үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?

Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ нь тогтоосон хугацаанд үр нөлөөтэй хэрэгжсэн байна.

Б.2.1. Тусламжийг холбогдох хуульд заасан шаардлагад нийцүүлэн зохих ёсоор хэрэгжүүлсэн үү?

Хандивлагч орон, олон улсын байгууллагын тусламжаар нийслэлд хэрэгжсэн 7 ТАХ-г Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан ЗГ-ын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”, болон холбогдох бусад хууль, дүрэм журамд заасан шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлсэн байна.

Үүнээс гадна нийслэлд 2016-2022 онуудад Монгол Улсын ЗГ-ын 2013 оны 394 дүгээр тогтоолоор хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам, Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн, малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журамд заасны дагуу малчдад урамшуулал олгожээ.

Хүснэгт №4 2016-2020 онд малчдад олгосон урамшуулал

№	Урамшуулал олгосон тогтоол	Арга хэмжээний нэр	Хамрагдах огноо	Малчны тоо	Тушаасан ноос, арьс ширний тоо	Мөнгөн дүг сая.төг
1	Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 394 дүгээр тогтоол	Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулах журмын хэрэгжилт	2016	243	69,6 тн	59.8
			2017	258	51,1 тн	64.2
			2018	180	33,5 тн	48.3
			2019	56	25,9 тн	38.4
			2020	168	48,6 тн	72.9
	Нийт			905	159,1 тн	283.6
2	Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 394 дүгээр тогтоол	Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн, малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулах журмын хэрэгжилт	2016	132	10939 ш	33.2
			2017	224	15489 ш	66.5
			2018	247	6849 ш	40
			2019	124	12460 ш	49.4
			2020	88	10397 ш	36
	Нийт			815	45195 ш	225.1

2016-2020 онд нийт 159.1тн хонь тэмээний ноос бэлтгэсэн үндэсний үйлдвэрт тушаасан 905 малчинд урамшууллын 283.6 сая төгрөг, үндэсний боловсруулах үйлдвэрт 45,195ш арьс, шир бэлтгэн тушаасан 815 хоршооны гишүүн, малчин, мал бүхий иргэдэд 225,1 сая төгрөгийг олгожээ.

Монгол Улсын ЗГ-ын тогтоол, ХХААХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргын тушаалыг тус тус үндэслэн 2016-2020 онуудад нийслэлд газар тариалан эрхэлдэг иргэдэд хүнсний ногооны үрийн дэмжлэг үзүүлсэн байна.

Хүснэгт №5 Хүнсний ногооны үрийн дэмжлэг					
№	Урамшуулал олгосон тогтоол	Арга хэмжээний нэр	Хамрагдах огноо	Олгосон үрийн дэмжлэг(кг)	Нэр төрөл
1	ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын А-173 дугаар тушаал	Хүнсний ногооны үрийн дэмжлэг	2016	532	3
2	-		2017	-	-
3	ХХААХҮ-ийн сайдын 2018 оны 05 сарын 04-ний өдрийн А-82 дугаар тушаал		2018	3419	15
4	Монгол улсын Засгийн газрын 2017 оны 09 сарын 22 өдрийн 278 дугаар тогтоол		2019	854	10
			2020	373.5	10
Нийт				5178.5	38

Нийт 38 нэр төрлийн 5178,5 кг хүнсний ногооны үрийг газар тариалан, жимс жимсгэнэ хүлэмжийн аж ахуй эрхэлдэг иргэдэд дэмжлэг тусламж хэлбэрээр 2021-2022 онуудад ЗГ-ын 2021 оны 142 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайдын А/135 дугаар тушаал, ЗГ-ын 2022 оны 118 дугаар тогтоолоор төмс, хүнсний ногооны үрийг олгох журмын дагуу 49,947 сая төгрөгийн 12,792.7кг үрийг иргэдэд 80 хувийн хөнгөлөлттэй үнээр олгожээ.

ЗГ-ын 2020 оны 130 дугаар тогтоолоор сүү боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эдийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуйн эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох” түр журам батлагдсанаар 2021-2022 онуудад нийт 2326 фермер эрхлэгч 7,4 сая литр сүүнд 3,661.0 сая төгрөгийн урамшууллыг олгожээ.

Дүгнэлт: Тусламж, дэмжлэгийн хөрөнгийг иргэдэд олгохдоо холбогдох хууль тогтоомж, журамд заасан шаардлагад нийцүүлжээ.

Б.2.2. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж дууссаны дараа үр дүнг тооцсон уу?

ЗГ-ын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 24.3¹, 24.5², 25.1.1-25.1.3³-д зааснаар төслийг дуусгавар болсонд тооцож тайлан мэдээг холбогдох газруудад хүргүүлж, 25.3-25.7-д зааснаар хэрэгжсэн ТАХ-ний хаалтын тайланг бэлтгэж, үр нөлөөг тооцохоор байна.

Гадаадын хандив тусламжийн 7 ТАХ-ээс 4 ТАХ бүрэн хэрэгжиж дууссан. Үүнд:

¹ 24.3. ТХН нь төсөл, арга хэмжээний төсвийн сар, улирал, хагас жил, жилийн эцсийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг төсөл хэрэгжүүлэгч байгууллагын ТЭЗ-ийн мэдээ, тайланд нэгтгүүлнэ

² 24.5. ТХН нь төсөл, арга хэмжээний улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дансны мэдээллийг дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор төсөл хэрэгжүүлэгч байгууллагын ТЭЗ-д, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 2 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсөл хэрэгжүүлэгч байгууллагын ТЭЗ-д хүргүүлнэ.

³ 25.1.1. гэрээ, хэлэлцээрт заасан төсөл хэрэгжих хугацаа дуусгавар болж, ажлууд бүрэн хэрэгжсэн;

25.1.2. энэ журмын 23.10-т заасан үндэслэлээр холбогдох шийдвэр гарсан;

25.1.3. гэрээ, хэлэлцээрт тусгасан ажил, арга хэмжээнүүд төлөвлөсөн хугацаанаас өмнө бүрэн хэрэгжсэн, эсхүл цаашид үргэлжлүүлэх шаардлагагүй болсон талаар холбогдох талууд харилцан тохиролцсон.

- Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Монгол ногоо төсөл (Жишиг гудамж),
- БНСУ-ын Инчон хотоос ТҮМ ТХ76 загварын трактор дагалдах тонон төхөөрөмжийн хамт буцалтгүй тусламжаар нийлүүлсэн
- АДРА Канад ОУБ-аас хэрэгжүүлсэн “Тогтвортой газар тариалан” төсөл
- БНСУ-ын Гёнгсан аймгийн Хаман сумын хоорондын найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд байгуулсан тарвасын хүлэмж төсөл

НХХААГ, дүүргүүдийн ХҮХҮ хэлтэс, ХАА-н тасгаас ОУБ-с хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнг тооцон байгууллагын хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайланд тусган ажиллажээ. Үүнд:

1. Монгол ногоо төслийн хүрээнд (жишиг гудамж) өрхүүдэд ногоо услах зориулалт бүхий гүн өрмийн 2 худгийг гаргасан. Загвар өрхүүдэд 32 мкв.метр талбай бүхий хүлэмж ус нөөцлөх сав, хүлэмжийн усалгааны систем, үр үрслэгийг олгосноор өрхийн хэрэгцээнд хүнсний ногоог тариалах ургацын үед худалдан борлуулж өрхийн амьжиргааг дээшлүүлэх зэрэг үр дүнд хүрсэн.
2. Инчон хотоос хандиваар өгсөн ТҮМ ТХ76 загварын тракторыг НХХААГ-аас 2021 оны 11 сарын 16-ны өдрийн №1 дугаартай ХААИС-ийн Инженер технологийн сургуультай сургалтын чиглэлээр ашиглуулахаар гэрээ байгуулжээ. Тогтвортой газар тариалан төсөлд хамрагдсан 220 өрх нь 2.7 га талбайд тариалалт эрхэлж, 64,8 тн ургац хураан авч, 8,10,14-р хороонд борлуулалтын цэг байгуулж, 16,5сая төгрөгийн борлуулалт хийж, өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд бодит үр дүн гарсан байна.

Харин ОУБ-ууд нь үр дүнгээ хэрхэн тооцоолсон талаарх мэдээлэл нийслэлд байхгүй байна.

Дүгнэлт: Тусламжийн хөрөнгөөр хэрэгсэн ТАХ нь иргэдийн амьжиргаанд бодит дэмжлэг үзүүлж үр дүнгээ өгсөн байна.

БҮЛЭГ В: ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙНА УУ?

В.1. Зээл тусламжийн хөрөнгийг олгох, хэрэгжүүлэх, ашиглахад тавих хяналт үр дүнтэй байна уу?

Зээл, тусламжийн хөрөнгийн явц, ашиглалтад НХХААГ, дүүргүүдийн ХҮХҮ хэлтэс, ХАА тасгуудаас хяналт хэрэгжүүлдэггүй, хагас, бүтэн жилээр явцын мэдээг авч тайлан бэлтгэж өгөх үүрэгтэй оролцдог байна.

В.1.1. Зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн мэдээллийн ил тод байдал хангагдаж байна уу?

Нийслэлийн хэмжээнд НХХААГ болон дүүргүүдийн ХАА тасгуудын хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлж буй ТАХ-үүдийн мэдээллийг өөрийн веб сайт (hhaag.ub.gov.mn)-аар болон ХАА-н салбарын нэгдсэн сан (Plant.gov.mofa.mn) зэргээр олон нийтэд мэдээлж, жилдээ 1 удаа нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулж хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан улс орон даяар нээлттэй хүргэдэг байна.

Энэхүү зөвлөгөөнөөр жилийн төлөвлөгөө, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар нээлттэй хэлэлцэж нэгдсэн мэдээллийг хүргэхээс гадна төсөл, хөтөлбөрүүдийн биелэлтийн мэдээллийг иргэдэд хүргэдэг байна.

Дүгнэлт: ХАА салбарт зээл, тусламжаар хэрэгжих ТАХ-ний мэдээллийг боломжит эх сурвалжаар дамжуулан нээлттэй мэдээлж үр дүнг тухай бүрд нь тайлагнадаг байна.

В.1.2. Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, арга хэмжээнд эрх бүхий байгууллагууд хяналт тавьж байна уу?

Нийслэлийн хэмжээнд 2016-2022 онуудад ЗГ-ын шугамаар зээл авсан 4 ТАХ, хандивлагч орон, олон улсын байгууллагаас тусламжийн хөрөнгөөр 7 ТАХ-нд НХХААГ, БНД, ХУД-үүдийн ЗДТГ-ууд дэмжиж хамтран ажиллах үүрэгтэйгээр санамж бичиг үйлдэн төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлжээ.

Гэвч эдгээр төсөл, хөтөлбөрүүдэд нийслэл, дүүргээс хяналт хэрэгжүүлдэггүй, хамтын ажиллагааны хүрээнд мэдээ тайлан авах, дэмжин туслах үүрэгтэй ажилладаг байна.

Дүрслэл № 9 ЗГ-ын зээл, хандивлагч орны хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-үүд



Нийслэлийн бүсэд ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, ААН-үүдийг дэмжих зорилго бүхий тусламжийн үр тариа, урамшуулалт хөтөлбөр зэрэгт НХХААГ-ын захиргааны хэлтсээс чиг үүргийн хүрээнд ажлын хэсэг байгуулж НЗДТГ, НЗАА-тай хамтарсан багаар болон дангаараа хяналтыг хэрэгжүүлдэг байна.

Дүрслэл № 10 Нийслэлийн бүсэд НХХААГ-аар дамжуулан хүнсний ногооны хөнгөлөлттэй үр олгосон ажлын биелэлт



Дүгнэлт: ЗГ-ын зээл, хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан ТАХ-нд нийслэлээс хяналтыг хэрэгжүүлдэггүй, явцын мэдээ тайланг авах чиглэлээр хамтран ажилладаг байна.

В.2. Зээл, тусламжийн ашиглалтад дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцож байна уу?

Бүрэн хэрэгжиж дууссан зээлийн хөрөнгөөр 1, тусламжийн хөрөнгөөр 5 ТАХ байна. Нийслэлээс эдгээрт дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах эрх зүйн зохицуулалт байхгүй.

Гэвч эдгээр төсөл, хөтөлбөрүүд нь бүрэн хэрэгжсэнээр иргэдийг тогтмол орлоготой болгох, тогтвортой ажлын байраар хангах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, тасралтгүй сургалтын хөтөлбөр болоод техник, тоног төхөөрөмжөөр хангах, байгаль орчин иргэдийн амьдралд тулгамдсан асуудлуудыг төслийн хэмжээнд шийдвэрлэх зэргээр эерэг өөрчлөлтүүдийг өгч эхэлсэн байна.

В.2.1. Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж байна уу?

НЗДТГ, дүүргүүдийн ЗДТГ болон НХХААГ-аас зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүрэг байхгүй, журмаар зохицуулагдаагүй байна.

Аудитаар талбарын үе шатны хяналтыг хэрэгжүүлэхэд төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлснээр газар тариалан, жимс жимсгэнэ, фермерийн үйлдвэрлэл эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжийг чадавхжуулах, дадлагажуулах, үйлдвэрлэл эрхлэх мэдлэгийг танхимын сургалтаар өгөх, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн гаргах чадамжуудыг эзэмшүүлэх зэрэг үр дүнг бий болгожээ.

НХХААГ, дүүргүүдийн ХҮХҮ хэлтэс, ХАА-н тасгууд хамтран ХХААХҮЯ-аас нийслэлийн ХАА-н салбарт бүртгэлтэй дэмжлэг хүссэн иргэдэд буцалтгүй тусламжаар олгодог хүнсний ногоо, жимс жимсгэнийн үр болон малын гаралтай түүхий эдийн урамшуулалт хөтөлбөрүүдийн үр дүнд жил бүр тогтмол судалгаа хийж ажилладаг байна. Үүнд:

1. Нийслэлийн бүсэд газар тариалангийн нэгдсэн системд бүртгэлтэй 946 тариаланч иргэн, ААН байдгаас нийслэлд идэвхтэй өрхийн болон ААН-н шугамаар хүнсний ногооны тариалалт эрхэлдэг 212 тариаланч 682,7га талбайд тариалалт хийж байна. Эдгээр иргэд, ААН-н үр тарианд зарцуулах санхүүгийн дарамтыг бууруулах, тариаланч өрх, ажлын байрыг хадгалах, ЗГ-ын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэргээр үр тарианы буцалтгүй тусламжийг 2016-2020 онуудад 100 хувь үнэгүй, 2021-2022 онуудад 80 хувийн

хөнгөлөлттэй үнээр олгож хэрэгжилтэд нь нийслэл, дүүргүүдээс жил бүр тогтмол хяналт хэрэгжүүлжээ.

Хүснэгт № 6 Нийслэлийн бүсэд үр тариан дэмжлэг үзүүлсэн иргэдийн ургац хураалтын мэдээ

Он	2016	2017	2018	2019	2020	2021	2022	Нийт
<i>Төмс, хүнсний ногоо (тн)</i>	8,106.2	4,388.6	6,167.5	6,488.3	5,892.5	5,829.6	7,118.6	43,991.3
<i>Хүлэмжний ургац (тн)</i>	1,383.9	2,340.0	2,340.0	2,080.4	2,542.6	2,582.6	2,582.6	15,852.1

1. 2016-2020 онуудад нийт давхардсан тоогоор 1720 малчинд 508.7 сая төгрөгийн урамшуулал олгожээ. Харин 2021 оноос иргэн, ААН-үүд и-баримтаар мэдээллээ оруулж урамшууллаа авдаг болсон байна.

Дээрх ТАХ-үүд хэрэгжсэнээр иргэдийн амьдралд дэмжлэг үзүүлж, хүнсний ногооны санхүүгийн дарамтыг бууруулж, малчдын орлого нэмэгдэж, ажлын байрыг тогтвортой хадгалж, дотоодын үйлдвэрлэлийн нөөц найдвартай хангагдах нөхцөл бүрдсэн зэрэг олон давуу талыг бий болгожээ. Мөн ТАХ-ны ашиглалтын байдал, гарч буй үр дүнтэй нь нийслэлийн харьяа байгууллагуудаас газар дээр нь очиж танилцан хагас, бүтэн жилийн тайлан мэдээг ногооны хураалтын байдлаар нь гарган нэгтгэж ажилладаг байна.

Дүгнэлт: Зээл, тусламжийн хөрөнгийн хэрэгжилтэд НХХААГ-аас гэрээнд заасны дагуу дэмжин туслах, төсөл, хөтөлбөрийн үр дүнг тооцож тайлан мэдээг жил бүр гаргадаг. Харин ТАХ-ний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргийг журмаар зохицуулаагүй байна.

В.2.2. Зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг зохих хууль тогтоомжийн дагуу бүртгэж, тайлагнаж байна уу?

2016-2022 оны хугацаанд хэрэгжиж дууссан зээл, тусламжийн хөрөнгөөр бүрэн хэрэгжиж дууссан, төсвийн байгууллагын данс бүртгэлд тусгагдах шаардлагатай зээлийн хөрөнгөөр 1, тусламжийн 3 ТАХ байна. Эдгээр ТАХ-с “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1⁴-дэх хэсэгт заасны дагуу 191.9 сая төгрөгийн өртөгтэй 3 ТАХ-г бүртгэлд тусгасан, 5.4 сая долларын өртөгтэй 1 ТАХ-г хөрөнгөд бүртгүүлэхээр НӨХГ-т албан тоот хүргүүлжээ.

Өмчид бүртгэгдсэн 3 ТАХ:

- Хан-Уул дүүргийн 13 дугаар хороонд байрлах “Хан-Уул Агро” парсад 50 метр урттай, 8 ширхэг “Тарвасын хүлэмж” (41.5 сая төгрөг)
- БНСУ-ын Инчон хотоос ТҮМ ТХ76 загварын трактор, дагалдах тоног төхөөрөмжийн хамт. (122.3 сая төгрөг)
- Баянгол цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ нь 2018 онд Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас зуны 4х8 хэмжээтэй 23 ширхэг, 6х20 хэмжээтэй 2 ширхэг нийт 25 хүлэмж (28.1 сая төгрөг)

Бүртгэлийн шатандаа 1 ТАХ:

- БНСУ-ын Койка ОУБ-ын санхүүжилтээр “Ногоон Ази сүлжээ” ТББ-н гүйцэтгэсэн “Жимс, жимсгэнийн боловсруулах үйлдвэр” (1,127.7 сая вон)

Дүгнэлт: Хэрэгжиж дууссан ТАХ-г нийслэлд хүлээлгэн өгч, хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу бүртгэлд тусгажээ.

⁴ 9.1. “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана.”

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Зээлээр хэрэгжүүлсэн ТАХ-үүд нь иргэн, ААН-ийн өрхийн үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж үр дүнтэй хэрэгжсэн байна.
2. Хандивлагч орон, ОУБ-ын тусламжаар нийслэл, дүүрэгтэй санамж бичгийн хүрээнд хамтран хэрэгжүүлсэн ТАХ-үүд нь орон нутаг, олон нийтийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байгаль орчинд ээлтэй, иргэдийн амьжиргаанд ач холбогдолтой арга хэмжээнүүд болжээ.
3. ХАА-н салбарын зээл, хандивлагч орон, ОУБ-н тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтийн явцад хяналтын чиг үүргийг нийслэл, дүүргийн байгууллагуудаас хэрэгжүүлэх зохицуулалтгүй, дэмжин туслах чиг үүргийн хүрээнд хамтран ажилладаг байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Д.Сумъяабазар)-д:

1. Хэрэгжиж дууссан БНСУ-ын Койка ОУБ-ын санхүүжилтээр "Ногоон Ази сүлжээ" ТББ-н гүйцэтгэсэн "Жимс, жимсгэнийн боловсруулах үйлдвэр"-ийг нийслэлийн өмчид бүртгэж, цаашид хэвийн үргэлжлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлж үйл ажиллагааны ашиглалт, үр өгөөжийг нь нэмэгдүүлэх.

Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газарт:

1. ОУБ-ын зээл, тусламжаар хэрэгжүүлэхээр санал болгож байгаа төсөл, хөтөлбөрүүдэд байгууллагын оролцоог нэмэгдүүлж хэрэгжилтийн үр дүнг тооцон ажиллах;
2. Нийслэлд ХАА-н чиглэлээр хэрэгжиж дууссан "Жимс, жимсгэнэ боловсруулах үйлдвэр"-ийг иргэдэд үр дүнтэйгээр ашиглуулж, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ


**НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
Жанжин Д.Сүхбаатарын талбай 7
1 дүгээр хороо, Чангантэй дүүрэг
Улаанбаатар хот, 15160 0035
Утас: (976-11) 32 71 99
Цахим хуудас: www.ubnhaag.gov.mn

2023. 07.06 № 05/4844
талай _____ -ны № _____ -т

**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

"Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн
хөрөнгийн ашиглалт, үр өгөөж"-д хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайланттай танилцлаа.

Аудитын тайланттай холбоотой санал байхгүй
бөгөөд цаашид аудитын тайлангаар өгөгдсөн
зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.


САНХҮҮ ТӨРИЙН
САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА **Н.НАРАНБААТАР**
ТТБ-а-2195

1110204049


**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР**
Нийслэлийн Засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,
Чангантэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7014 0423
Цахим хуудас: info@hhaag.ub.gov.mn
Цахим хуудас: www.hhaag.ub.gov.mn

2023.07.18 № 01/367
талай _____ -ны № 1003 -т

НИЙСЛЭЛ ДЭХ АУДИТЫН ГАЗАРТ

Манай байгууллагад хэрэгжсэн Хөдөө аж
ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн
ашиглалт, үр өгөөжид хийсэн гүйцэтгэлийн
аудитын тайланттай танилцлаа. Тусгайлан
саналгүй болно.

 Нийслэлийн Хүнс, Хөдөө Аж Ахуйн Газар
Удирдлага
Дарга
Хандсүрэн Эрдэнэбилэг
2023.07.18 14:49